МБҮА ТББ НЬ ОЛОН УЛСЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕРҮҮДИЙН ХОЛБОО (ФИДИК)-НД “ТҮНШЛЭГЧ ГИШҮҮН”-ЭЭР ЭЛСЭХЭЭР БОЛЛОО

ОЛОН УЛСЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕРҮҮДИЙН ХОЛБОО (ФИДИК) нь МБҮА ТББ-ыг “ТҮНШЛЭГЧ ГИШҮҮН”-ээр элсүүлэх шийдвэрийг 2023.09.08-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурал, улмаар 2023.09.10-ны өдрийн Сингапурт болсон ФИДИК-ийн Ерөнхий Ассамблейн хурлаараа (GAM) оруулан соёрхон баталлаа. ФИДИК нь Швейцарын Женев хотноо 1913.07.22-ны өдөр үүсгэн байгуулагдаж, эдүгээ дэлхийн 100 гаруй гишүүн байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжин тэлж, Сургалт, судалгаа (ФИДИК-ийн Академи, Гэрчилгээжүүлэлт), Жишиг гэрээ (Suite of Contracts), Маргаан шийдвэрлэлт, Эвлэрүүлэн зуучлал чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.



International Federation of Consulting Engineers
The Global Voice of Consulting Engineers

Mongolian National Construction Association NGO
MN Tower, Floor 8, Suite 805, 806, 811
Chingeltei district, 5th khoroo
Mongolia

Geneva, 20 September 2023

Re. FIDIC Membership - Mongolian National Construction Association NGO

Dear Sir, Madame,

We are contacting you today, to inform you that during the Board's meeting on 8 September 2023 and then after ratification during the FIDIC General Assembly Meeting (GAM) on 10 September 2023 in Singapore, your application for FIDIC Associate Membership was approved. Congratulations!

To that extent, please note that now our finance office will be preparing the relevant communication for the invoice reflecting your subscription fees for 2023-2024. In that light, you are requested to send us as soon as possible your updated reported staff numbers (RSN).

Please note that "reported staff numbers" (RSN) is defined as: all staff employed in the country of the Member Association by its Member firms/companies (permanent, contract and agency staff associated with the built and natural environment on local and/or on overseas business). Staff numbers shall be full time equivalents, and include managerial, technical, support and administrative staff.

The above information should be sent to the Secretariat no later than **30 September 2023.**

We thank you for your time and ongoing support to FIDIC and we congratulate you once again on becoming associate members.

We will contact you shortly to schedule a meeting with you for introductions to FIDIC directors and the chair of the FIDIC Directors & Secretaries Advisory Council.

We look forward to further strengthening our relationship and working closer with you so that you get the most of your FIDIC membership.

Best regards,

Italo Goyzueta
Federation Operations Director
FIDIC

FIDIC SECRETARIAT
World Trade Center II, Geneva Airport, P.O. Box 311, CH-1215 Geneva 15, Switzerland
+41 22 560 0980 - www.fidic.org - IDE Number CHE-106.022.602 TVA

ФИДИК-ийн гишүүн орон болсноор тухайн гишүүн нь дараах эрхийг эдэлдэг байна. Үүнд:

– ФИДИК-ийн сургалтыг зохион байгуулах (гишүүний хөнгөлөлт, тусгайлсан сургалтыг зохион байгуулах хүсэлтийг гаргах)
– ФИДИК-ийн бүс нутгийн холбоонд нэгдэх (FIDIC Asia-Pacific), бусад гишүүн бүхий холбоодтой харилцах
– ФИДИК-ээс эрхлэн гаргасан бүтээлийг орчуулах эрхийг авах
– ФИДИК-ээс эрхлэн гаргасан бүтээлийг хэвлэх эрхийг авах (зөвхөн Гишүүн холбоо нь)
– ФИДИК-ийн барааны тэмдгийг тодорхой хүрээнд ашиглах эрхийг авах (лого ашиглах, нэрийн хуудас, веб хуудас, албан бичиг дээрээ байрлуулах г.м)
– ФИДИК-ээс эрхлэн гаргаж буй бүтээлүүд, тэдгээрийн шинэчлэлийн талаарх мэдээллийг авах
– ФИДИК-ээс явуулсан судалгааны үр дүнтэй танилцах
– ФИДИК-ийн албан ёсны үйл ажиллагаа, хурал, зөвлөгөөнийг зохион байгуулах эрхийг авах зэрэг болно.

МБҮА ТББ-ыг Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо (ФИДИК)-нд элсэхэд Монгол Улсын Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ) болон Азийн ба Баруун Номхон Далайн Гэрээлэгчдийн Ассоциациудын Олон Улсын Нийгэмлэг (IFAWPCA)-с ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛСЭН АЛБАН БИЧГИЙГ авч илгээсний дагуу ФИДИК-ийг Монгол Улсад төлөөлөх “Түншлэгч гишүүн” нь болж, барилга, хот байгуулалтын салбарт ФИДИК-ийн гэрээг хэрэгжүүлэх үйл явцыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, сурган чадавхжуулах ажлыг зохион байгуулах, салбарын үйл ажиллагаанд оролцогч хөрөнгө оруулагч, захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч нарын хоорондын харилцааг зохицуулах, эрх тэгш байдлыг хангах, хамгаалан

ажиллах үүргийг хүлээх, улмаар Монгол Улсад ФИДИК-ийн мэдээллийг болон гэрээг түгээх Гишүүн болон үндэсний хэмжээний холбоодын нийтлэг мэргэжлийн эрх ашгийг хөгжүүлэх, Монгол Улсын барилгын салбарт Олон улсын гэрээ, эрх зүйн орчныг олон улсын стандартын дагуу хэрэгжүүлэн шинэ дэвшил, эргэлтийг авчрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг эрхлэх болно.

МБҮА ТББ-ыг ФИДИК-д “ТҮНШЛЭГЧ ГИШҮҮН”-ээр элсүүлэх ажил үйлсэд сүүлийн 3 жилийн хугацаанд өөрсдийн хичээл зүтгэл, ур чадвар, санаа санаачилгаа гарган үр дүнтэй ажилласан МБҮА ТББ-ын Хүндэт ерөнхийлөгч Д.Цэрэнжигмэд, Гүйцэтгэх захирал Л.Хулан, УЗГ, “Эс Ди инженеринг энд констракшн” ХХК-ийн Захирал Б.Баасансүрэн, Хуулийн зөвлөх Б.Сумъяажав, Ажлын албаны “Дулаан шийдэл 2” төслийн Төслийн зохицуулагч, Хамтын ажиллагаа хариуцсан ажилтан Г.Номин болон Ажлын албаны хамт олонд баяр хүргэж, эхлүүлсэн энэ ажил үйлсэд нь цаашдын амжилтын дээдийг хүсэн ерөөе.

МБҮА ТББ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИД, УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД, НИЙТ ГИШҮҮД, АЖЛЫН АЛБАНЫ ХАМТ ОЛОН
2023.10.06